



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 14/05

Пионер толгой

**Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Сумын Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд холбоо,мэдээлэл хүлээн авах станцын зориулалтын газрыг Засаг даргын тамгын газарт олгохыг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА  Ч.ЭРДЭНЭ-ОЧИР



648801027

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн  
ээлжит 14 дүгээр хуралдааны 14/05  
дугаар тогтоолын Хавсралт



**ГУРВАНБУЛАГ СУМЫН 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ**

30501001		ХОЛБОО, МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ ХҮЛЭЭН АВАХ СТАНЦ										
№	Сум	Баг	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын байршил нэгж талбар бүрээр	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ	Улирал I	Улирал II	Улирал III	Улирал IV	Хариуцах эзэн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Гурванб улаг	Буга 3-р баг	3479676	X=475129.975Y=5242966.068 X=475149.747Y=5242966.047 X=475149.747Y=5242945.808 X=475129.936Y=5242945.827		3401: Холбоо, мэдээлэл хүлээн авах станц	400 м2	+	+	+	+	ЗДТГ, Газрын даамал

.....000.....